



Библи дээр үндэслэсэн бизнесийг

ЭХЛҮҮЛЭХ НЬ...

Математик дасгалын ном 1

**Санхүүгийн тооцоонуудыг хийхэд зориулсан
Дасгалын ном 1-ийн энгийн асуултууд**

Бэлэн жишээнүүд ба хариултууд – хувилбар 2.0

**Зохиогчид: Жон НЖ Давис & Майкл Кларго
Колчестер Өөрчлөлт Бизнесийн Бүлэг**

Өөрийн жижиг бизнесийг эхлүүлэх нь:

Угандагийн жижиг бизнесийн цуврал удирдамж

Математикийн дасгалын ном 1

Танилцуулга

Энэ математикийн ном нь Дасгал ном 1-ийн сэдвүүдийг хамарсан Библи дээр суурилсан бизнесийн цуврал жишээнүүд болон дасгалуудыг тодруулж тус нэмэр болохоор загварчлагдсан. Хэсэг бүр дасгалын номонд байгаа тодорхой сэдвүүдийг багтаадаг. Эдгээр хэсгүүд ерөнхийдөө бэлэн жишээгээр эхэлдэг бөгөөд тус бүртээ гурван дасгалууд дагалдсан болно.

Бүх жишээн дээрх мөнгөн дүн Доллар дээр иш татагдсан. Сургалт явагдаж байгаа тухайн газраас хамаарч, суралцагчдад жишээнүүдийг илүү ойр байлгахын тулд, валютыг тухайн орон нутгийн мөнгөн дүнд шилжүүлэх хэрэгтэй.

Зарим нэг илүү төвөгтэй асуултууд байгаа ба санаа нь номны арын хэсэгт хариултуудын хамт өгөгдсөн байгаа

1-р хэсэг: Зах зээлийг тооцоолох нь

Дасгал номны 21-р хуудас, 13-р дасгал нь хүрч болох бизнесийн зах зээл болон зах зээлийн хувь ноогдолыг хэрхэн тооцоолж болохыг харуулдаг. Доорх зах зээлийн тооцоонуудын бэлэн жишээнд 3 дасгал өгөгдсөн нь ийм маягийн тооцоонуудыг таниар хийлгэхийн тулд юм.

Бэлэн жишээ

“Кампала Компьютер Компани” (ККК) нь шинэ компани бөгөөд хойд Кампала дахь жижиг бизнесүүдийг дэмжин туслахаар компьютерийн техник санал болгодог. Хотын энэ хэсэгт ойролцоогоор 50 орчим жижиг бизнесүүд компьютерийн үйлчилгээ явуулдаг. Тэдгээр бизнес бүр асуудалтай тулгардаг ба дунджаар сард 1-2 компьютерт дор хаяж 2 удаа засвар үйлчилгээ хийлгэх хэрэгтэй болдог. Дуудлага бүрийн дундаж хөлс нь 150\$. ККК нь зардлаа нөхөхөд жилдээ 45000\$-ын орлого олохоор зорьж байгаа.

Дуудлагын тоо (энэ төрлийн бизнест эдгээр нь борлуулалт нь болдог)

Тухайн орон нутаг дах жижиг бизнесүүдийн тоог (50) бизнес бүрийн дуудлагын дундаж тоогоор (2) үржүүлвэл хойд Кампала дах жижиг бизнесүүдийн сарын дуудлагын тоо гарна.

Сар бүрийн дуудлагын тоог (100) жилийн (12) сардаа үржүүлэхэд жилийн нийт дуудлагын тоо гарна.

Энэ тохиолдолд жилийн дуудлагын тоог (1,200) дундаж дуудлагын үнэ (150\$)-р үржүүлэхэд жилдээ хүрч болох зах зээлийн борлуулалтын тоо гарч ирнэ.

Нөгөөтэйгүүр энэ нь хүрч болох зах зээл гэж нэрлэгддэг.

ККК нь зардлаа нөхөхийн тулд жилд олох шаардлагатай (45000\$)-г хүрч болох зах зээл буюу хойд Кампала дахь бүх жижиг бизнесээс жилд олж болох үнийн дүнд (180000\$) хуваагаад 100-р үржүүлэхэд (тухайн ноогдолыг хувь руу шилжүүл) зах зээлийн хувь ноогдол (хувиар илэрхийлэгддэг) гарч ирнэ.

50 (бизнесүүд)
x 2 (бизнес тус бүрийн, сард
дуудагдах дуудлага)

= 100 (сарын дуудлага)

100 (сарын дуудлага)
x 12 (жил дэх сарууд)

= 1,200 (жил бүрийн дуудлага)

1,200 (жил бүрийн дуудлага)
x 150 (дуудлага бүрийн үнэ)

= 180,000 (Хойд Кампала дахь
бүх жижиг бизнесүүдээр жилд
төлөгдөх үнэ - үүнийг хүрч
болох зах зээл гэж хэлдэг.)

45,000 (ККК-н орлого, хэрэгцээ)
÷ 180,000 (хүрч болох зах зээл)
x 100 (зуун % руу шилжүүл)

= 25%

Дасгалууд

Одоо таны ээлж. Хэрвээ танд хэрэгтэй бол нэмэлт цаас ашиглаж болно. Доорх дасгалууд дээр бизнес тус бүрийн жилийн бүх хүрч болох зах зээл болон зах зээлийн хувь ноогдолыг тооцоолж бод.

Дасгал 1.1

“Дугуйн Хаан” компани нь саяхнаас унадаг дугуйнуудыг Уборад зарж эхэлсэн. Тухайн орон нутагт 2 өрсөлдөгч компани байдаг. Тэд сард тус тусдаа дунджаар 50 унадаг дугуй зардаг. Унадаг дугуйны дундаж үнэ нь 80\$. “Дугуйн хаан” компани жилд 12000\$ орлого олохоор зорьж байгаа.

Хүрч болох зах зээл = \$ _____

“Дугуйн хаан” зах зээлийн
хувь ноогдол = ____%

Дасгал 1.2

Кенийн албан тасалгаа цэвэрлэх үйлчилгээ (КАЦҮ) нь “Төв Найроби” дахь оффисуудаар цэвэрлэгээ хийж үйлчлэхийг санал болгодог. Тэр хэсэгт 120 орчим оффисууд байдаг ч тэдгээр байгууллагуудын гуравны нэг нь өөрсдийн цэвэрлэгчдийг авч ажиллуулдаг ба өөр компаниас ажиллуулдаггүй. Оффисууд сард 2 удаа цэвэрлэгддэг ба цэвэрлэгээ бүрийн дундаж үнэ нь 300\$ байдаг. (КАЦҮ) –н жилийн орлого нь 144,000\$

Хүрч болох зах зээл = \$ _____

КАЦҮ-н зах зээлийн хувь ноогдол = ____%

Дасгал 1.3

“Виктория Жуулчин Компани” (ВЖК) нь Виктория нуураар усан онгоцоор аялахыг санал болгодог. Сар бүр 150 жуулчид Виктория нуурын аялалд зориулж завь түрээслэдэг ба тус бүрт нь 20\$ төлдөг. ВЖК-н жилийн орлого нь 14,400\$

Хүрч болох зах зээл = \$ _____

ВЖК Зах зээлийн хувь ноогдол = ____%

Хуудасны энэ талыг дасгал ажилдаа хэрэглэнэ үү?

2-р хэсэг: Орлого, Зарлага & Ашиг

Дасгал ном 1, 30-33 хуудас нь сарын борлуулалтын тоо ширхэг буюу нэгж үнэнээс сарын орлогыг хэрхэн тооцож гаргах, сарын энэхүү орлого ба нийт зардлуудаас бизнесийнхээ ашиг (алдагдал)-г хэрхэн тооцоолж гаргахыг харуулдаг. Доорх тооцоолсон бэлэн жишээнүүдэд 3 дасгал дагалдсан болно.

Бэлэн жишээ

Монгол Загас Компани (МЗК) нь Хяргас нуурын хойд хэсэгт загасчилдаг ба түүнийгээ Баруунтуруун сумын зах дээр зарж борлуулдаг. Тус зах нь сард 4 удаа ажилладаг ба зах ажиллах болгонд МЗКомпани нь 60 загас борлуулж чаддаг байна. Загас бүр дунджаар 2\$ -аар тэнд зарагддаг. Одоогоор МЗКомпаны үйл ажиллагааны зардалууд нь* сар бүрийн зээлийн эргэн төлөлтөнд 150\$ (зээл нь завь бас тор худалдан авахад зориулагдсан), сар бүрийн цалинд 90\$, сарынхаа бензин түлшинд 60\$ зарцуулдаг байна. Сар бүрийн орлого, үйл ажиллагааны зардал мөн ашиг (эсхүл алдагдал) нь хэд байх вэ?

Зах ажиллах бүрт зарагдах борлуулалтын тоо ширхэгийг (60 загас) сард зах ажиллах тоогоор (4) үржүүлэхэд сарын нийт борлуулалтын тоо ширхэг гарч ирнэ.

Зарах загас нэг бүрийн үнэ (\$2)-г сарын нийт борлуулалтын тоо (\$240)-р үржүүлэхэд сарын дундаж орлого гарч ирнэ.

Сарын үйл ажиллагааны нийт зардалыг гаргахын тулд* сарын үйл ажиллагаа тус бүрийн зардлуудыг хооронд нь нэмнэ: *зээлийн эргэн төлөлт (\$150), цалин хөлс (\$90), шатахуун (\$60) г.м*

Сарын нийт орлого (\$480)-с сарын нийт зардал (\$300)-г хасахад сарын ашиг гарч ирнэ.

60 (зах бүрт зарагддаг загас)
x 4 (сард Баруунтуруун дах захын ажиллах тоо)

= 240 (1сард зарагдах загасбуюу сарын нийт борлуулалт)

\$2 (Нэг загасны дундаж үнэ)
x 240 (Сард зарагдах загасбуюу сарын нийт борлуулалт)

= \$480 (МЗКомпаний загасны борлуулалтаас орж ирэх нэг сарын орлого)

\$150 (нэг сард төлөгдөх зээлийн эргэн төлөлт)
+ \$90 (нэг сарын цалин хөлс)
+ \$60 (1сарын шатахууны зардал)

= \$300 (1 сарын үйл ажиллагааны нийт зардал)*

\$480 (МЗК-н нийт борлуулалтаас орж ирэх сарын орлого)
- \$300 (сарын үйл ажиллагааны нийт зардал)*

= \$180 (нэг сарын ашиг)

* Санамж: Эдгээр үйл ажиллагааны зардлуудыг зөвхөн жишээ болгон авсан ба бодит амьдралд ойртуулан дасгал ажиллахад амар хялбар болгосон. Мөн энэ бизнесийг явуулж байгаа өөр зардлууд болох засвар үйлчилгээ, даатгал, татвар, үйл ажиллагааны төлбөрүүд г.м бусад зардлууд байгаа болно.

Дасгалууд

Одоо таны ээлж. Хэрвээ танд хэрэгтэй бол нэмэлт цаас ашиглаж болно. Доорх компаниудын сарын орлого, үйл ажиллагааны зардлууд, ашиг (эсхүл алдагдал) зэргийг тооцоол.

Дасгал 2.1

“Ланжоу Цай Компани” нь цай зардаг ба кг бүрийг нь \$0.30-р зардаг. Энэ цай нь сар бүр 15.000 кг зарагддаг. Мөн 10ажилтан тус бүрт 300\$, зээлийн эргэн төлөлтөнд 900\$ төлдөг.

Нэг сарын орлого = \$ _____

Нэг сарын үйл ажиллагааны зардлууд = \$ _____

Ашиг эсвэл алдагдал = \$ _____
(аль нь вэ)

Дасгал 2.2

“Чанчун Алчуур” дэлгүүр нь тус бүр нь 7 \$-н үнэтэй алчууруудыг 1сард 200 ширхэгийг импортолдог. Нэг алчуур 9.75\$ үнэтэй зарагддаг. Үүнд 2 ажилтан ажилладаг ба тус бүрт нь сард 250\$, дэлгүүрийн байрны түрээсэнд 40\$, сар бүр төлдөг зээлийн эргэн төлөлтөнд 50\$ тус тус төлдөг.

Сарын орлого = \$ _____

Сарын үйл ажиллагааны зардлууд = \$ _____

Ашиг эсвэл алдагдал = \$ _____
(аль нь вэ)

Дасгал 2.3

Фрэнк Вампамба бол самрын худалдаачин. Тэрээр сард 5 шуудай самрыг тус бүрийг нь 30\$-р худалдаж авдаг. Нэг шуудайнд 100 уут самар савлагдсан байдаг ба тус бүрийг нь 0.40\$-р зардаг. Тэр зээлийн эргэн төлөлтөнд сар бүр 20\$ төлдөг.

Сарын орлого = \$ _____

Сарын үйл ажиллагааны зардлууд = \$ _____

Ашиг эсвэл алдагдал = \$ _____
(аль нь вэ)

Хуудасны энэ талыг дасгал ажилдаа хэрэглэнэ үү?

3-р хэсэг: Тогтмол ба хувьсах зардлууд

Дасгал ном 1, 34-р хуудас нь тогтмол ба хувьсах зардлуудын хоорондын ялгааг тайлбарладаг. Тогтмол зардлууд нь таны хийх ажлын хэмжээнээс болж өөрчлөгдөхгүй байхад хувьсах зардлууд нь өөрчлөгдөж байдаг.

Дасгал

Доор дурьдсан зардлууд тус бүрийг тогтмол зардал уу, хувьсах зардал уу гэдгийг нь тодорхойл.

Түрээс	Тогтмол / Хувьсах*
Түүхий эд	Тогтмол / Хувьсах
Бүтэн цагийн ажилчдын цалин хөлс	Тогтмол / Хувьсах
Хэрэглээний зүйлс (жнь: бичиг хэргийн)	Тогтмол / Хувьсах
Түр ажилчдын цалин хөлс	Тогтмол / Хувьсах
Цахилгаан	Тогтмол / Хувьсах
Зар сурталчилгаа	Тогтмол / Хувьсах

* Аль нэг үгийг нь дарж арилга.

Таны өөрийн тогтмол болон хувьсах зардлуудаа бичихэд зориулсан хуудас.

4-р хэсэг : Бодит бус ба Бодит зардал

Дасгал ном 1, 36-37 хуудсууд нь бодит бус зардал дээр үндэслэн хийгдсэн бизнесийн бодит, хувьсах үйл ажиллагааны зардлууд болох бүтэн үнээрээ зарагдах боломжтой сайн нэгж бүтээгдэхүүнүүдийн тоо ширхгийг хэрхэн тооцоолон гаргаж ирэхийг харуулдаг.

Бэлэн жишээ

Дасгал ажил 1, 38-р хуудас нь жигнэмэгийн үйлдвэрийн жишээг бидэнд харуулж өгдөг.

Дасгалууд

Одоо таны ээлж. Хэрвээ танд хэрэгтэй бол нэмэлт цаас ашиглаж болно. Доорх бизнесүүдэд зориулан сар бүрийн бодит зардлыг нь тооцоол.

Дасгал 4.1

“Нагпур” талхны цех нь өдөрт 100ш талх барьдаг ба нэг талхны үнэ нь 2.40\$. Эдгээр талхнуудаас дунджаар 5% нь түлэгдэж, 15% нь бэлэн болсныхоо дараа эвдэрч хэмхэрдэг байна. (жнь: хэн нэгэн ажилтны буруу үйл ажиллагааны улмаас). Тус талхны цех нь сарын 25 өдөрт нь ажилладаг ба зөвхөн сайн талхнуудаа л зардаг.

100 нэгж бүтээгдэхүүний
бодит бус зардал = \$ _____
100 –д ногдох сайн
нэгжийнх нь тоо ширхэг = _____
Нэгж бүрийн бодит зардал = \$ _____
Сар бүрийн бодит, хувьсах
зардал = \$ _____

Дасгал 4.2

“Бапатиа Загасны Тор” компани нь Хайдерабадаас загасны торнуудыг ширхэг бүрийг нь 54\$-р импортолдог. Дунджаар сард хэрэглэх боломжгүй, согогтой (тор нь цоорхой & урагдсан) ба хүлээн авах боломжгүй болсон 5 орчим тор гарч ирдэг. Сард дунджаар 50 ш загасны тор худалдан авдаг.

100 нэгж бүтээгдэхүүний
бодит бус зардал = \$ _____
100-д ногдох сайн
нэгжийнх нь тоо ширхэг = _____
Нэгж бүрийн бодит зардал = \$ _____
Сар бүрийн бодит, хувьсах
зардал = \$ _____

Дасгал 4.3

Абел Фрийман гэгч хүн дэлгүүрээр явж жимс зардаг. Тэр 300ш жүрж худалдан авдаг ба тус бүрийг нь 0,20\$-т хүргүүлдэг. Эдгээрээс 20 нь ялзарч, 40 ширхгийг нь орон нутгийн хүүхдийн асрах газарт хандив болгон өгсөн. Тэр сард 600 ш жүрж зардаг.

100 нэгж бүтээгдэхүүний
бодит бус зардал = \$ _____
100 –д ногдох сайн
нэгжийнх нь тоо ширхэг = _____
Нэгж бүрийн бодит зардал = \$ _____
Сар бүрийн бодит, хувьсах
зардал = \$ _____

Хуудасны энэ талыг өөрийн дасгал ажилдаа хэрэглэнэ үү?

5-р хэсэг: Эхлэлтийн зардлууд

Дасгал ном 1, 39-р хуудас нь бизнесийн эхлэлтийн зардлууд, бэлтгэж суурилуулах зардлууд, таны эхлэлтийн хөрөнгө (зээл ч юмуу) хүлээж авах тухайн цаг үе ба сарын үйл ажиллагааны зардлууд (бид 2-р бүлэг, дасгал номны 5-р бүлэгээс харсан) зэргийг хэрхэн тооцоолж болохыг харуулдаг. Доорх эхлэлтийн зардлыг тооцоолсон бэлэн жишээнүүдэд 3 дасгал дагалдсан болно.

Бэлэн жишээ

Кампо Флорида компаний сарын нийт төлбөрийн хуудас нь(ажилчдын цалин) 600\$, цахилгаан, гааз ба бусад хэрэглээнүүдийн жилийн төлбөр нь 1800\$ байдаг. 2003 оны 1 сард тус компани нь бэлтгэл ажилдаа орсон ба тухайн сардаа 8000\$-р тээврийн хэрэгсэл, мөн 3000\$-р бусад зайлшгүй хэрэгцээтэй тавиур ба компьютер гэх мэт зүйлсийг худалдаж авсан байна. 2003 оны 4 сард Хавана дэлгүүрт худалдаагаа хийж эхэлсэн.

Сарын үйл ажиллагааны зардал гэдэг нь сарын төлбөрийн тооцооны хуудас (600\$) болон цахилгаан, гааз гэх мэт бусад хэрэглээний жилийн төлбөрийн (1800\$) 1/12-н нийлбэр дүн юм.

Авсан зээлээ зарцуулж эхэлснээс хойш анхны орлого хүлээн авах хүртэлх хугацаа нь 3сар (2003оны 1-4-р сар хүртэл). Тиймээс нэг сарын үйл ажиллагааны зардлаа 3 сардаа үржүүлвэл анхны орлого хүртэлх үйл ажиллагааны зардал гарч ирнэ.

Бэлтгэн суурилуулах зардал гэдэг нь тээврийн хэрэгслийн (8000\$) ба бусад зайлшгүй хэрэгцээт зүйлсийн(3000\$) зардлуудын нийлбэр юм.

Эхлэлтийн нийт зардал гэдэг нь бэлтгэн суурилуулах зардал болон орлого орохоос өмнөх үйл ажиллагааны зардлуудын нийлбэр дүнг хэлнэ.

\$1800 (Хэрэглээнүүдийн жилийн төлбөр)
/ 12 (Нэг жил дэх сарын тоо)
<hr/>
\$150 (Хэрэглээнүүдийн сарын зардал)
\$150 (Хэрэглээнүүдийн сарын зардал)
+ \$600 (Ажилчдын цалингийн сарын төлбөр)
<hr/>
= \$750 (сарын үйл ажиллагааны зардлууд)
\$750 (сарын үйл ажиллагааны зардлууд)
*3 (Эхэлснээс эхний орлого хүртэлх сар)
<hr/>
\$2250 (2003 оны 1-4сар хүртэлх 3 сарын үйл ажиллагааны зардлууд)
\$8000 (Тээврийн хэрэгслийн зардал)
+ \$3000 (тавиур, компьютер гэх мэт зардал)
<hr/>
= \$11000 (Бэлтгэн суурилуулах зардал)
\$11000 (Бэлтгэн суурилуулах зардал)
+ \$2250 (3 сарын үйл ажиллагааны зардлууд)
<hr/>
= \$13,250 (нийт эхлэлтийн зардлууд)

Дасгалууд

Одоо таны ээлж. Хэрвээ танд хэрэгтэй бол нэмэлт цаас ашиглаж болно.
Доорх компаниудын бүх эхлэлтийн зардлуудыг тооцоол.

Дасгал 5.1

“Лима Бэвэрэйчс Эмпориум” компани нь бизнес эрхлэх байр болон тоног төхөөрөмжинд зориулж 2500\$-г 2004 оны 1сарын 1нд төлсөн. Тухайн жилийнхээ 10сарын 1-с бүтээгдэхүүнээ худалдаж эхэлсэн. Энэ хугацааны туршид сарын төлбөрийн хуудас (байр, цахилгаан г.м) 200\$ байсан ба сар бүр үйлчилгээ болон бусад төлбөрүүдэд 100\$ зарцуулсан.

Орлого орохоос өмнөх үйл ажиллагааны зардлууд = \$ _____
Бэлтгэх зардлууд = \$ _____
Эхлэлтийн бүх зардлууд = \$ _____

Дасгал 5.2

“Арекипа” Тээврийн үйлчилгээний компани нь 2007оны 1сарын 1нд 45,000\$ р автобус худалдаж авсан. Мөн тухайн үедээ 300\$-н цалинтай жолооч болон тус бүр 210\$ цалинтай офиссийн 2 ажилтанг ажилд авсан байна. Тус компаний анхны төлбөр төлөх хугацаа нь 6 сарын 1-д байсан ба мөн энэ өдөр анхны орлогоо хүлээн авсан.

Орлого орохоос өмнөх үйл ажиллагааны зардлууд = \$ _____
Бэлтгэх зардлууд = \$ _____
Эхлэлтийн нийт зардлууд = \$ _____

Дасгал 5.3

“Такна” Компьютерийн үйлчилгээний компани нь анхныхаа үйл ажиллагаагаа 2006 оны 3 сарын 1нд зайлшгүй хэрэгцээнд зориулж компьютерийн тоног төхөөрөмжийн төлбөрт 8,000\$ төлснөөр эхэлсэн ба тухайн үедээ өөр 4,000\$-г тээврийн хэрэгсэл худалдаж авахад зарцуулсан байна. Мөн оффисын түрээсэнд сарын 200\$, оффисийн 2 ажилчдад тус бүр нь сард 250\$-г төлж байсан. Энэ компаний анхны орлого 2006 оны 8 сарын 1нд орж ирсэн.

Орлого орохоос өмнөх үйл ажиллагааны зардлууд = \$ _____
Бэлтгэх зардлууд = \$ _____
Эхлэлтийн нийт зардлууд = \$ _____

Хуудасны энэ талыг дасгал ажилдаа хэрэглэнэ үү?

6-р хэсэг: Ашиг алдагдлын цэг

Дасгал ном 1ын 40-42 хуудсанд бизнесийн эхний үе шат дах зээлийн өртөг ба ашиг алдагдлын цэгийг хэрхэн тооцоолох тухай авч үзсэн. Ашиг алдагдлын цэг гэдэг нь бизнесийнхээ зардлуудыг төлж барагдуулахын тулд шаардагдах нэгжийн борлуулалтын тоо ширхэг дээр зээлийн эргэн төлөлтийн дүнг нэмээд гарах нийлбэр юм. Хуудас 42 дах тооцоонууд нь ашиг алдагдлын цэгийг тооцоолон бодохыг харуулдаг.

Бэлэн жишээ

Тирана сантехникийн үйлчилгээний компаний (ТСҮ) гол бизнес нь усны эвдэрсэн хоолойнуудыг засах юм. Тэд энэ ажлаа хийхээр үйлчлүүлэгчдээрээ үе үе дуудагддаг. Тэдний нэг удаагийн үйлчилгээний үнэ нь дунджаар 20\$ байдаг. ТСҮ компаний нэг удаагийн үйлчилгээ үзүүлэхэд гардаг бодит зардлууд гэвэл материал, тээвэр, ажилчид гэх мэт дунджаар 15\$ болдог. ТСҮ компаний сарын тогтмол зардал нь 200\$ байдаг ба 1200\$-н зээлтэй.

Борлуулалт (үйлчилгээ) бүрээс олох мөнгө нь үйлчилгээний дундаж үнэ (20) –ээс үйлчилгээ бүрт гарах бодит зардлыг хассанаар гарч ирнэ:

Сарын нийт тогтмол зардлууд нь зээлийн зардлын $\frac{1}{4}$ дээр сарын тогтмол зардлуудыг нэмсэнээр гарч ирнэ:

Ашиг алдагдлын цэг нь нийт гарах тогтмол зардалаа нэгж бүрээс хүлээн авах мөнгөндөө хувааснаар гарч ирнэ:

\$20	(үйлчилгээний дундаж үнэ)
-\$15	(нэг удаагийн үйлчилгээний бодит зардал)
<hr/>	
= \$5	(ТСҮ компаний үйлчилгээ үзүүлэх бүрт олдог бодит мөнгө)
\$1200	(зээлийн хэмжээ)
/4	(дөрөвний нэг)
<hr/>	
= \$300	(сарын зээлийн эргэн төлөлт ¹)
\$300	(сарын зээлийн эргэн төлөлт)
+\$200	(сарын тогтмол зардал)
<hr/>	
= \$500	(сарын нийт тогтмол зардлууд)
\$500	(сарын нийт тогтмол зардлууд)
/ \$5	(нэгж бүрээс хүлээн авах мөнгө – ТСҮ компаний үйлчилгээ үзүүлэх бүрт олдог бодит мөнгө)
= 100	(тогтмол зардлуудыг барагдуулахын тулд сард дор хаяж үзүүлэх үйлчилгээний тоо)

Тирана сантехникийн үйлчилгээний компани нь алдагдалд орохгүйн тулд сард 100 үйлчилгээ үзүүлэх хэрэгтэй гэсэн үг. Үүнээс өчүүхэн ч бага байх юм бол тэд мөнгөө алдах ба эцсийн дүндээ бизнесээ ч алдах болно.

¹ Нийтлэг эргэн төлөлтийн хэмжээ нь сардаа нийт зээлийн $\frac{1}{4}$ -р тооцогддог.

Дасгалууд

Одоо таны ээлж. Хэрвээ танд хэрэгтэй бол нэмэлт цаас ашиглаж болно. Доорх өгөгдсөн компаниудын ашиг алдагдлын цэгийг тооцоол.

Дасгал 6.1

Паксол Радио Компани (ПРК) нь радио зардаг ба дунджаар 1ш радиог 5\$ зардаг. ПРК компаний 1ш радионы бодит зардал нь 3\$. Тус компани түрээсэнд жилд 840\$ төлдөг ба өөр тогтмол зардал гардаггүй. Харин 80 \$-н зээлийн өртэй.

Нэгж бүрээс орох мөнгө = \$ _____

Сарын тогтмол зардлууд = \$ _____

Ашиг алдагдлын цэг = _____ нэгж

Дасгал 6.2

КастосКекс компани кекс зардаг ба дунджаар 1ш кексийг 0,50\$-р зардаг. 1ш кексний бодит зардал нь 0,10\$. Тус компани түрээсэнд жилд 600\$ төлдөг ба 400\$ зээлийн өртэй.

Нэгж бүрээс орох мөнгө = \$ _____

Сарын тогтмол зардлууд = \$ _____

Ашиг алдагдлын цэг = _____ нэгж

Дасгал 6.3

Итаки Тоосго компани нь 100ш тоосгыг дунджаар 7\$ зардаг. 100ш тоосгоноос гарах бодит зардал нь 4\$. Тус компани нь түрээсэнд сард 100\$, ажилтныхаа цалинд 300\$ төлдөг. Мөн 2000\$ зээлийн өртэй.
(тайлбар: 100ш тоосгыг 1нэгжид авч үзнэ)

Нэгж бүрээс орох мөнгө = \$ _____

Сарын тогтмол зардлууд = \$ _____

Ашиг алдагдлын цэг = _____ нэгж

Хуудасны энэ талыг дасгал ажилдаа хэрэглэнэ үү?

7-р хэсэг: Бэлэн мөнгөний урсгалыг тооцох

Дасгал ном 1, 43-р хуудас нь бэлэн мөнгөний эргэлтийг тайлбарласан. Хавсралт 1т бэлэн мөнгөний эргэлтэнд дүн шинжилгээ хийхэд зориулсан нарийвчилсан хуудсыг агуулдаг. Энэ хэсэгт бид бэлэн жишээгээ даган 3 үндсэн бэлэн мөнгөний эргэлтийн хүснэгтийг та өөрөө бөглөн ажиллах болно.

Орлого, зарлага мөн зээлийн эргэн төлөлтүүд нь сар бүр эхлэлтийн баланстайгаа тухайн сардаа хамтдаа өгөгдөх болно. Бусад бүх дансны гүйлгээнүүд нэг бүрчлэн тооцогдсон байх хэрэгтэй.

Бэлэн жишээ

Өгөгдлүүд нь өгөгдсөн – Хоосон дөрвөлжинг бүгдийг нь бөглө. (бүх мөнгөн дүн \$ доллараар)

Сар	1	2	3	4	5	6
Эхлэлтийн баланс (o)	1000					
Орлого (i)	0	0	400	700	900	900
Зарлага (e)	300	300	300	300	300	300
Зээлийн эргэн төлөлт (l)	150	150	150	150	150	150
Баланс хаах (c) $c=o+i-e-l$						

Тооцоолж гаргасан дүнгүүд (налуугаар бичсэн нь өгөгдлүүд)

Сар	1	2	3	4	5	6
Эхлэлтийн баланс (o)	1000	550 (1-р сарын төгсгөл баланс)*	100 (2-р сарын төгсгөл баланс)*	50 (3-р сарын төгсгөл баланс)*	300 (4-р сарын төгсгөл баланс)*	750 (5-р сарын төгсгөл баланс)*
Орлого (i)	0	0	400	700	900	900
Зарлага (e)	300	300	300	300	300	300
Зээлийн эргэн төлөлт (l)	150	150	150	150	150	150
Баланс хаах(c) $c=o+i-e-l$	1000 +0 -300 -150 <hr/> =550	550 +0 -300 -150 <hr/> =100	100 +400 -300 -150 <hr/> =50	50 +700 -300 -150 <hr/> =300	300 +900 -300 -150 <hr/> =750	750 +900 -300 -150 <hr/> =1200

* Сар бүрийн эхэнд танд байх мөнгө нь өмнөх сарын төгсгөлд танд байсан мөнгө юм.

Дасгалууд

Одоо таны ээлж. Хэрвээ танд хэрэгтэй бол нэмэлт цаас ашиглаж болно.

Доорх бэлэн мөнгөний дүн шинжилгээний хүснэгтэнд байгаа хоосон нүхнүүдийг бүгдийг нь бөглө. (бүх мөнгөн дүн Угандагийн шиллингээр).

Дасгал 7.1

Сар	1	2	3	4	5	6
Эхлэлтийн баланс (o)	2000					
Орлого (i)	0	300	600	900	1100	1200
Зарлага (e)	600	600	600	600	600	600
Зээлийн эргэн төлөлт (l)	350	350	350	350	350	350
Баланс хаах (c) $c=o+i-e-l$						

Дасгал 7.2

Сар	1	2	3	4	5	6
Эхлэлтийн баланс (o)	100					
Орлого (i)	0	0	50	60	80	90
Зарлага (e)	25	25	30	40	50	60
Зээлийн эргэн төлөлт (l)	20	20	20	20	20	20
Баланс хаах (c) $c=o+i-e-l$						

Дасгал 7.3

Сар	1	2	3	4	5	6
Эхлэлтийн баланс (o)	200					
Орлого (i)	0	0	0	80	90	90
Зарлага (e)	40	40	40	50	60	60
Зээлийн эргэн төлөлт (l)	20	20	20	20	20	20
Баланс хаах (c) $c=o+i-e-l$						

Хариултууд

1-р хэсэг

1.1	Хүрч болох зах зээл	2 бизнес x 50 нэг сарын дугуй x 12 сар (жилд) x \$80 нэг дугуй <hr/> = \$96,000 (жилд)
	Зах зээлийн хувь ноогдол	\$12,000 “Дугуйн хаан”-ы жилийн төлөвлөсөн орлого : \$96,000 хүрч болох зах зээл x 100 (хувь руу шилжүүлэх) <hr/> = 12.5%
1.2	Хүрч болох зах зээл	120 Төв Найроби дахь оффисууд x 2/3 Өөрсдийн цэвэрлэгчгүй оффисуудын харьцаа x 24 бүтэн жилд хийх боломжтой цэвэрлэгээний тоо (сард 2 удаа) x \$300 Нэг удаагийн цэвэрлэгээний дундаж тариф <hr/> = \$576,000 Нэг жилд
	Зах зээлийн хувь ноогдол	\$144,000 “КАЦҮ”компаны жилийн төлөвлөсөн орлого ч \$576,000 Хүрч болох зах зээл x 100 (хувь руу шилжүүлэх) <hr/> = 25%
1.3	Хүрч болох зах зээл	150 Аялагчдын тоо (нэг сард) x 12 сарууд (нэг жилд) x \$20 Онгоцоор аялах тариф (нэг аялагч) <hr/> = \$36,000 (нэг жилд)
	Зах зээлийн хувь ноогдол	\$14,400 ВЖК компаний жилийн төлөвлөсөн орлого ч \$36,000 хүрч болох зах зээл x 100 (хувь руу шилжүүлэх) <hr/> = 40%

2-р хэсэг

2.1	Сарын орлого	\$0.30 (1кг цайны зарах үнэ) x 15,000 kg (нэг сард зарагддаг цайны хэмжээ)
		<hr/> = \$4,500
	Сарын үйл ажиллагааны зардлууд	10 ажилчин x \$300 сарын цалин (1ажилчин) + \$900 Зээлийн эргэн төлөлт (1сард)
		<hr/> = \$3,900
	Ашиг эсвэл алдагдал	\$4,500 сарын орлого – \$3,900 сарын үйл ажиллагааны зардлууд
		<hr/> = \$600 (ашиг) нэг сард
2.2	Сарын орлого	\$9.75 зарагдах алчуур нэг бүрийн орлого x 200 сард зарагдах алчуурны тоо
		<hr/> = \$1,950
	Сарын үйл ажиллагааны зардлууд	\$1,400 алчуурнуудын үнэ (200алчуур x 7\$ тус бүр) + \$500 сар бүрийн цалин (2 ажилтан x 250\$) + \$40 худалдаа хийх газрын сарын түрээсний үнэ + \$50 зээлийн эргэн төлөлт (сард)
		<hr/> = \$1,990
	Ашиг эсвэл алдагдал	\$1,950 сарын орлого – \$1,990 сарын үйл ажиллагааны зардлууд
		<hr/> = –\$40 (алдагдал) нэг сард
2.3	Сарын орлого	\$0.40 ууттай самрын үнэ x 100 нэг шуудайн дах ууттай самрын тоо x 5 шуудай (1сард)
		<hr/> = \$200
	Сарын үйл ажиллагааны зардлууд	5 шуудай самар (сард) x \$30 худалдан авах 1шуудай самарны үнэ + \$20 зээлийн эргэн төлөлт (сард)
		<hr/> = \$170
	Ашиг эсвэл алдагдал	\$200 сарын орлого – \$170 сарын үйл ажиллагааны зардлууд
		<hr/> = \$30 (ашиг)

Түрээс	Тогтмол / Хувьсах
Түүхий эд	Төгтмөл / Хувьсах
Бүтэн цагийн ажилчдын цалин хөлс	Тогтмол / Хувьсах
Хэрэглээний зүйлс (жнь: бичиг хэргийн)	Төгтмөл / Хувьсах
Түр ажилчдын цалин хөлс	Төгтмөл / Хувьсах
Цахилгаан	Тогтмол / Хувьсах
Зар сурталчилгаа	Тогтмол / Хувьсах

4-р хэсэг

4.1 100 нэгж бүтээгдэхүүний бодит бус зардал	100 x \$2.40	100 x талх бүрийн бодит бус зардал
	= \$240	
100 сайн нэгж бүтээгдэхүүний тоо ширхэг	100 талх x 95% түлэгдээгүй – 15 буруу хандсанаас болж алдагдсан.	
	= 80 талх	
Нэгж бүрийн бодит зардал	\$240	100ш талх үйлдвэрлэхэд (сайн & муу) : 80 сайн талхны тоо
	= \$3	
Сар бүрийн бодит хувьсах зардлууд	\$3 сайн талх бүрийн бодит зардал x 80 өдөрт зарагдах талх x 25 нэг сард ажиллах хоногийн тоо	
	= \$6,000	
4.2 100 нэгж бүтээгдэхүүний бодит бус зардал	100 x \$54	100 x тор бүрийн бодит бус зардал
	= \$5,400	
100 сайн нэгж бүтээгдэхүүний тоо ширхэг	100 тор – 10 (50 бүрээс 5нь хүлээн авах боломжгүй)	
	90 тор	
Нэгж бүрийн бодит зардал	\$5,400	100тор худалдаж авахад (сайн & муу) : 90 худалдаж авах сайн торын тоо
	\$60	
Сар бүрийн бодит хувьсах зардлууд	\$60 сайн тор бүрийн бодит зардал x 50 нэг сард худалдах тор	
	\$3,000	
4.3 100 нэгж бүтээгдэхүүний бодит бус зардал	100 x \$0.20	100 x жүрж бүрийн бодит бус зардал
	= \$20	
100 сайн нэгж бүтээгдэхүүний тоо ширхэг	100 жүрж – 7 ялзарсан (300-д 20ш) – 13 хандивласан (300-д 40ш)	
	80 жүрж	
Нэгж бүрийн бодит зардал	\$20	100 жүрж авахад (сайн & муу) : 80 зарагдах боломжтой жүржийн тоо
	\$0.25	
Сар бүрийн бодит хувьсах зардлууд	\$0.25 зарагдах жүржийн бодит зардал x 600 нэг сард зарагдах жүрж	
	\$150	

5-р хэсэг

5.1	Орлого орохоос өмнөх үйл ажиллагааны зардлууд	\$200 сарын төлбөрийн хуудас + \$100 төлбөрүүд ба үйлчилгээнүүд х 9 сар (1-10сар хүртэл)
		<hr/> \$2,700
	Бэлтгэх зардлууд	\$2,500 ажлын байр болон тоног төхөөрөмж
		<hr/> \$2,500
	Эхлэлтийн нийт зардлууд	\$2,700 орлого орохоос өмнөх үйл ажиллагааны зардлууд + \$2,500 бэлтгэх зардлууд
		<hr/> \$5,200
<hr/>		
5.2	Орлого орохоос өмнөх үйл ажиллагааны зардлууд	\$300 жолоочийн сарын цалин + \$420 оффисийн ажилтны сарын цалин х 2 х 5 сар (1-6 сар хүртэл)
		<hr/> \$3,600
	Бэлтгэх зардлууд	\$45,000 автобус
		<hr/> \$45,000
	Эхлэлтийн нийт зардлууд	\$3,600 орлого орохоос өмнөх үйл ажиллагааны зардлууд + \$45,000 Бэлтгэх зардлууд
		<hr/> \$48,600
<hr/>		
5.3	Орлого орохоос өмнөх үйл ажиллагааны зардлууд	\$500 сарын төлбөрийн хуудас (2 employees) + \$200 оффисийн сарын түрээс х 5 сар (3-8 сар хүртэл)
		<hr/> \$3,500
	Бэлтгэх зардлууд	\$8,000 компьютерийн тоног төхөөрөмж \$4,000 тээврийн хэрэгсэл
		<hr/> \$12,000
	Эхлэлтийн нийт зардлууд	\$3,500 орлого орохоос өмнөх үйл ажиллагааны зардлууд + \$12,000 Бэлтгэх зардлууд
		<hr/> \$15,500

6-р хэсэг

6.1	Нэгж бүрээс орох мөнгө	\$5 нэг радионы зарах үнэ – \$3 радио бүрийн үйлдвэрлэх зардал
		<hr/> \$2
	Сарын тогтмол зардлууд	\$80 зээлийн өр : 4 j (эргэн төлөлтийн нийтлэг хэмжээ) + \$840 жилийн түрээс : 12 нэг сарын түрээс рүү шилжүүлэх
		<hr/> \$90 (\$20 эргэн төлөлт + \$70 түрээс)
	Ашиг алдагдлын цэг	\$90 сарын тогтмол зардлууд : \$2 зарах 1ш радианоос орох мөнгө
		<hr/> 45 сар бүр 45ш радио
6.2	Нэгж бүрээс орох мөнгө	\$0.50 нэг кексний зарах үнэ – \$0.10 кекс бүрийн үйлдвэрлэх зардал
		<hr/> \$0.40
	Сарын тогтмол зардлууд	\$400 зээлийн өр : 4 j (эргэн төлөлтийн нийтлэг хэмжээ) + \$600 жилийн түрээс : 12 нэг сарын түрээс рүү шилжүүлэх
		<hr/> \$150 (\$100 эргэн төлөлт + \$50 түрээс)
	Ашиг алдагдлын цэг	\$150 сарын тогтмол зардлууд : \$0.40 зарах 1ш кекснээс орох мөнгө
		<hr/> 375 сар бүр 375ш кекс
6.3	Нэгж бүрээс орох мөнгө	\$7 багцийн (100ш тоосго) зарах үнэ – \$4 багцийн (100ш тоосго) үйлдвэрлэх зардал
		<hr/> \$3
	Сарын тогтмол зардлууд	\$2,000 зээлийн өр : 4 j (эргэн төлөлтийн нийтлэг хэмжээ) + \$100 сарын түрээс + \$300 сарын цалин
		<hr/> \$900 (500\$ эргэн төлөлт + 400\$)
	Ашиг алдагдлын цэг	\$900 сарын тогтмол зардлууд : \$3 зарах багц бүрээс (100 ш тоосго) орох мөнгө.
		<hr/> 300 багц (100ш тоосго)

7-р хэсэг

7.1

Сар	1	2	3	4	5	6
Эхлэлтийн баланс	2000	1050	400	50	0	150
Орлого	0	300	600	900	1100	1200
Зарлага	600	600	600	600	600	600
Зээлийн эргэн төлөлт	350	350	350	350	350	350
Төгсгөлийн баланс	1050	400	50	0	150	400

7.2

Сар	1	2	3	4	5	6
Эхлэлтийн баланс	100	55	10	10	10	20
Орлого	0	0	50	60	80	90
Зарлага	25	25	30	40	50	60
Зээлийн эргэн төлөлт	20	20	20	20	20	20
Төгсгөлийн баланс	55	10	10	10	20	30

7.3

Сар	1	2	3	4	5	6
Эхлэлтийн баланс	200	140	80	20	30	40
Орлого	0	0	0	80	90	90
Зарлага	40	40	40	50	60	60
Зээлийн эргэн төлөлт	20	20	20	20	20	20
Төгсгөлийн баланс	140	80	20	30	40	50